



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголросцвемтет ТӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/050/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг:
baterdenee@audit.gov.mn

Б энд С аудит ХХК-ийн Захирал: Д.Заяажаргал
Утас: 99050268 Цахим хаяг: info@auditllc.com

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 99075081 Цахим хаяг: bcauditllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 02/1185
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголпросцветмет ТӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,556.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Тендер сонгон шалгаруулахгүйгээр нэр бүхий компанитай вагон түрээсийн гэрээ байгуулж, урьдчилан 24,096.8 сая төгрөг, гэрээний биелэлт хангагдаагүй 20,773.5 сая төгрөгийн авлагатай байхад 2024 оны 2,3 дугаар сард нэмж 100 вагоны түрээсийн төлбөрт 5,767.7 сая төгрөг төлсөн, нийлүүлэгч талд давуу байдал олгосон;
- Тайланд онд 25,146.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлээс 149.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2011-2021 онуудад үүссэн 443.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй;
- Нөхөн сэргээлтийн нөөц өр төлбөрийг Зүүн цагаан дэлийн далд уурхайд байгуулаагүй, урьд үүсгэсэн нөхөн сэргээлтийн нөөц санд жил бүр өөрчлөлт оруулаагүй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа,

ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.1.1, 32.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6, Сангийн сайдын 2016 оны 409 дүгээр тушаалаар батлагдсан “Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын 4 дүгээр зүйлийн 4.5.2.1, 4.5.2.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Урьдчилж төлсөн зардал тооцоо болон ирээдүй цагийн зардал дансанд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд хөрс хуулалт, үйлдвэрлэлийн үе шатны зардлыг эргэлтийн бус хөрөнгөнд шилжүүлэн бүртгээгүйгээс өмнөх онуудын санхүүгийн тайланг буруу илэрхийлсэн байна.

“Далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн үйл ажиллагааны зардалд тайлант онд Монголросцветмет ТӨҮГ-аас 909.2 сая төгрөг, Эрдэнэс Тавантолгой ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 4,319.4 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 5,228.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нью стар энерги ХХК-тай 2022 онд байгуулсан 2,313.2 сая төгрөгийн дизель түлш нийлүүлэх гэрээний дагуу төлбөрийг хугацаандаа төлөөгүйгээс үүссэн гэрээний алданги 200.0 сая төгрөгийг Шүүхийн шийдвэрээр эвлэрлийн гэрээ байгуулан төлсөн.

Дизель түлш нийлүүлэх худалдан авах тендерт шалгарсан Трак лимитед ХХК нь шатахуун импортлох, бөөнөөр болон жижиглэнгээр борлуулах тусгай зөвшөөрлийн хугацаа тендер шалгаруулсанаас хойш нэг сарын дараа дууссан ба тусгай зөвшөөрлийг сунгаагүй байна.

Бусад асуудал

Аудитын тайлан гарахаас өмнө зарим шаардлагатай гэрээ, контрактыг ирүүлээгүй нь аудитын хамрах хүрээг хязгаарласан ч аудитын дүгнэлтийг дэмжих хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог цуглуулсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,126,228,646.29	5,442,815,355.87
1.1.2	Авлага	2,357,114,856.28	11,657,808,620.13
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	8,895,553,848.66	8,871,198,344.78
1.1.4	Бусад авлага	3,715,922,385.88	4,617,881,071.67
1.1.6	Бараа материал	141,714,154,040.36	131,779,308,080.47
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	118,309,274,200.61	14,661,920,592.44
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		9,658,526,245.88
1.1.11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>280,118,247,978.08</u>	<u>186,689,458,311.24</u>
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	137,148,574,854.53	139,242,376,324.51
1.2.2	Биет бус хөрөнгө	5,889,211,327.34	5,777,958,634.86
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	10,752,024,140.87	8,323,962,989.86
1.2.6	Уул уурхайн хөрөнгө		139,428,356,656.72
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	34,941,805.24	1,960,795.78
1.2.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө	32,012,967,998.11	14,448,746,889.77
1.2.10	Дуусаагүй барилга	1,033,778,702.54	1,033,778,702.54
1.2.11	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>186,871,498,828.63</u>	<u>308,257,140,994.04</u>
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>466,989,746,806.71</u>	<u>494,946,599,305.28</u>
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансын өглөг	40,712,224,709.11	47,298,741,962.77
2.1.1.2	Цалингийн өглөг	4,220,676,858.72	3,674,452,126.92
2.1.1.3	Татварын өр	30,737,306,320.43	50,941,566,814.95
2.1.1.4	НДШ-ийн өглөг	2,830,342,571.50	914,157,172.65
2.1.1.5	Богино хугацаат зээл	34,094,224,068.30	34,189,401,502.78
2.1.1.6	Хүүний өглөг	321,297,502.93	25,852,814.72
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	23,383,320,000.00	23,383,320,000.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	124,277,295,395.11	107,337,752,396.15
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	1,898,191,514.48	2,725,880,885.41
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	382,484,124.71	7,517,979,661.92
2.1.1.13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	<u>262,857,363,065.29</u>	<u>278,009,105,338.27</u>
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	355,803,687.56	355,803,687.56
2.1.2.3	Бусад урт хугацаат өр төлбөр	8,800,000.00	8,800,000.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	<u>364,603,687.56</u>	<u>364,603,687.56</u>
2.2	ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	<u>263,221,966,752.85</u>	<u>278,373,709,025.83</u>
2.3.1	Өмч: - төрийн	1,226,788,000.00	1,226,788,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	52,631,132,657.47	50,800,617,425.48
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,641,413,040.00	2,641,413,040.00
2.3.10	Хуримтлагдсан ашиг	147,268,446,356.39	161,904,071,813.97
2.3.20	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>203,767,780,053.86</u>	<u>216,572,890,279.45</u>
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	<u>466,989,746,806.71</u>	<u>494,946,599,305.28</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО /цэвэр/	216,354,837,575.16	295,226,284,400.67
2	БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ	102,975,904,150.08	141,725,429,357.51
3	НИЙТ АШИГ /АЛДАГДАЛ/	113,378,933,425.08	153,500,855,043.16
4	Түрээсийн орлого	257,196,961.36	131,439,557.61
5	Хүүгийн орлого	19,544,156.68	18,592,922.53
8	Бусад орлого	4,610,408,754.08	16,575,926,185.08
10	Ерөнхий ба удирдлагын зардал	12,654,976,352.42	14,586,458,772.65
11	Борлуулалт, маркетингийн зардал	54,333,185,612.94	81,621,095,566.82
12	Санхүүгийн зардал	2,836,530,175.26	4,689,704,694.18
13	Бусад зардал	12,373,713,783.85	32,423,365,204.64
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз/гарз	144,327,688.87	9,740,774.36
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз	(191,337,910.85)	(7,420,138.98)
18	ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ/АЛДАГДАЛ	36,020,667,150.75	36,908,510,105.47
19	Орлогын татварын зардал	10,558,198,786.77	11,190,808,171.60
20	ТАТВАРЫН ДАРААХ АШИГ/АЛДАГДАЛ	25,462,468,363.98	25,717,701,933.87
22	ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ/АЛДАГДАЛ	25,462,468,363.98	25,717,701,933.87
24	ОРЛОГЫН НИЙТ ДҮН		

2. 3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	52,657,728,803.97	20,741,413,040.00	104,166,764,805.29	178,792,694,649.26
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(18,100,000,000.00)	18,279,303,720.62	179,303,720.62
3	Залруулсан үлдэгдэл	1,226,788,000.00	52,657,728,803.97	2,641,413,040.00	122,446,068,525.91	178,971,998,369.88
4	Тайлант үеийн үр дүн				25,462,468,363.98	25,462,468,363.98
5	Зарласан ногдол ашиг				(666,686,680.00)	(666,686,680.00)
6	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(26,596,146.50)		26,596,146.50	
11	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	52,631,132,657.47	2,641,413,040.00	147,268,446,356.39	203,767,780,053.86
19	Тайлант үеийн үр дүн				25,717,701,933.87	25,717,701,933.87
20	Өмчид гарсан өөрчлөлт				(4,255,352,464.48)	(4,255,352,464.48)
21	Ногдол ашиг				(8,657,239,243.80)	(8,657,239,243.80)
22	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(1,830,515,231.99)		1,830,515,231.99	
23	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,226,788,000.00	50,800,617,425.48	2,641,413,040.00	161,904,071,813.97	216,572,890,279.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	286,015,399,879.47	301,121,821,623.26
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	278,716,042,151.09	284,310,796,230.78
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	85,820,286.00	379,246,112.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,213,537,442.38	16,431,779,280.48
1.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	274,612,619,574.75	275,793,201,212.55
1.2.1	Ажиллагчдад төлсөн	58,824,250,028.27	69,772,039,162.95
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	17,675,219,292.38	21,659,269,145.02
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	32,271,023,570.51	22,456,980,507.91
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	34,148,791,489.31	33,099,757,392.75
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	98,249,083,551.92	72,832,968,901.23
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	2,528,690,155.09	4,985,703,255.42
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	14,154,674,208.16	32,747,738,501.04
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	323,582,344.27	299,228,132.98
1.2.9	Бусад мөнгөн зарлага	16,437,304,934.84	17,939,516,213.25
1.3	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,402,780,304.72	25,328,620,410.71
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	19,383,132.24	18,336,253.47
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	19,383,132.24	18,336,253.47
2.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	22,805,238,843.17	16,510,049,902.44
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	22,619,756,349.02	16,325,921,543.44
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	185,482,494.15	184,128,359.00
2.3	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(22,785,855,710.93)	(16,491,713,648.97)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (+)	23,275,213,040.00	2,600,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	23,275,213,040.00	2,600,000,000.00
3.2	МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (-)	6,900,380,104.65	11,257,621,829.84
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	4,733,693,424.65	2,600,382,586.04
3.2.4	Төлсөн ногдол ашиг	2,166,686,680.00	8,657,239,243.80
3.3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	16,374,832,935.35	(8,657,621,829.84)
4	Валютын ханшийн зөрүү	(95,061,412.43)	137,301,777.68
4	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	4,896,696,116.71	316,586,709.58
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	229,532,529.58	5,126,228,646.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,126,228,646.29	5,442,815,355.87

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгсгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 он		Биелэлт /харьцуулалт/, %	
				Төлөвлөгөө	Г үйцэтгэл	Зөрүү	Хувь
1.0	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт ба борлуулалт						
1.1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт Хайлуур жоншны бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.тн	-		0.5	(0.5)	-
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.тн	664.3	751.6	786.9	(35.4)	1.2
	Цайрын баяжмал	мян.тн	1.4	6.5	1.8	4.7	1.3
	Алт олборлолт	кг	9.8				
1.2	Бүтээгдэхүүн борлуулалт Хайлуур жоншны бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	0.6	4.0	4.7	(0.7)	7.8
	Төмрийн баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	730.4	811.6	985.8	(174.3)	1.3
	Цайрын баяжмалын бүтээгдэхүүний борлуулалт	мян.тн	5.6	6.5	0.3	6.2	0.1
	Төмрийн хүдрийн борлуулалт	мян.тн	115.7	545.0	259.2	285.8	2.2
	Алтны борлуулалт	кг	9.8				
2.0	Нийт борлуулалтын орлого	мян.төг	221,241,987.0	262,340,727.0	311,961,983.8	(49,621,256.8)	18.9
2.1	Үүнд: ФФ-95 флотацын баяжмалын борлуулалт	мян.төг	546,864.0	5,491,424.0	5,301,213.0	190,211.0	9.7
2.2	ФК-75 металлургийн баяжмалын борлуулалт	мян.төг	141,489.0		238,145.0	(238,145.0)	1.7
2.3	Ее-65 төмрийн нойтон баяжмалын борлуулалт	мян.төг	71,044,120.0	64,501,489.0	93,105,454.0	(28,603,965.0)	1.3
2.4	Ее-52 төмрийн хуурай баяжмалын борлуулалт	мян.төг	115,308,478.0	20,078,019.0	172,129,422.0	(152,051,403.0)	1.5
2.5	2п-50 цайрын баяжмалын борлуулалт	мян.төг	17,433,156.0	130,661,975.0	881,065.0	129,780,910.0	0.1
2.6	Төмрийн хүдрийн борлуулалт	мян.төг	9,706,612.0	37,410,326.0	14,946,199.0	22,464,127.0	1.5
2.7	Алтны борлуулалт	мян.төг	2,174,118.0			-	-
2.8	Бусад орлого	мян.төг	4,887,150.0	4,197,494.0	25,350,745.0	(21,153,251.0)	5.2
	Гадаад валютын ханшийн олз (гарз)				9,740.8	(9,740.8)	
3.0	Нийт зардал	мян.төг	236,487,080.0	229,300,191.2	275,053,473.7	(45,753,282.5)	19.9
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	25,351,457.0	11,603,505.0	19,276,163.0	(7,672,658.0)	0.7
	Нийгмийн хариуцлагын хүрээний зардал	мян.төг	6,822.4	9,535,552.0	8,023,345.0	1,512,207.0	1.2
4.0	Татварын өмнөх ашиг	мян.төг	36,020,667.0	33,040,536.0	36,908,510.0	(3,867,974.0)	1.0
5.0	Цэвэр ашиг	мян.төг	25,462,468.0	24,818,284.0	25,717,702.0	(899,418.0)	1.0
6.0	Төсөвт төлөх татвар, шимтгэл	мян.төг	75,487,336.0	62,925,379.0	81,470,148.0	(18,544,769.0)	1.1
6.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	мян.төг	10,473,720.0	8,222,251.0	11,190,808.0	(2,968,557.0)	1.1
6.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	мян.төг	13,893,114.0	8,961,304.0	10,120,792.0	(1,159,488.0)	0.7
6.3	АМНАТ	мян.төг	24,717,147.0	23,756,714.0	26,976,814.0	(3,220,100.0)	1.1
6.4	Ус ашигласны төлбөр	мян.төг	2,151,774.0	1,010,468.0	1,413,392.0	(402,924.0)	0.7
6.5	Газрын төлбөр	мян.төг	249,406.0	412,821.0	246,903.0	165,918.0	1.0
6.6	Галт зэвсгийн албан татвар	мян.төг	930.0	991.0	930.0	61.0	1.0
6.7	Агаарын бохирдлын төлбөр	мян.төг	1,984.0	1,593.0	1,714.0	(121.0)	0.8

6.8	Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	26,059.0	29,819.0	26,534.0	3,285.0	1.0
6.9	Гадаадын ажиллах хүч ажиллуулсны татвар	мян.төг	-	13,200.0	18,960.0	(5,760.0)	-
6.1	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	мян.төг	17,141,490.0	13,168,142.0	19,679,353.0	(6,511,211.0)	1.1
6.1	Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	260,440.0	238,963.0	301,469.0	(62,506.0)	1.1
6.1	ХХОАТ	мян.төг	6,253,128.0	7,109,112.0	6,962,005.0	147,107.0	1.1
6.1	Бусад татвар	мян.төг	318,142.0		4,530,474.0	(4,530,474.0)	14.2
7.0	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	9,789,100.0	12,318,984.0	8,657,239.0	3,661,745.0	0.88
8.0	Ажиллагсдын дундаж хүний тоо	хүн	1,634.0	1,756.0	1,644.0	112.0	1.0
9.0	Цалингийн сан	мян.төг	68,685,170.0	90,152,705.0	88,936,476.0	1,216,229.0	1.3
10.0	Ажиллагсдын сарын дундаж цалин	мян.төг	3,500,975.0	4,626,251.0	4,836,337.0	(210,086.0)	1.4
11	Үйл ажиллагааны бус зардал				7,420.1	(7,420.1)	
11.1	Үндсэн хөрөнгө дансаас хассаны олз (гарз)				7,420.1	(7,420.1)	
13.0	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	0,78	0.8	0.9	(0.0)	1.1
13.0	Нийт авлага	мян.төг	14,968,592.0	1,814,407.0	25,146,888.0	(23,332,481.0)	1.7
	Үүнээс: Найдваргүй авлага	мян.төг		438,842.0	443,468.0	(4,626.0)	-
14.0	Нийт өглөг	мян.төг	263,221,967.0	110,820,885.0	278,009.1	110,542,875.9	1.06
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	262,857,363.0	110,456,281.0	277,644,502.0	(167,188,221.0)	1.0
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	364,604.0		364,604.0	(364,604.0)	1.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 7,556.5 сая төгрөгийн 10 зөрчил илэрснээс, 5,767.7 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 1,035.0 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 753.8 сая төгрөгийн 6 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэрийн шатахууны үлдэгдэлд биет тест хэрэгжүүлэхэд 21.882 кг буюу 73.7 сая төгрөгийн шатахуун илүү үлдэгдэлтэй байна.	1	73,734.7						1	73,734.7				
Тендер сонгон шалгаруулахгүйгээр нэр бүхий компанитай вагон түрээсийн гэрээ байгуулж, урьдчилан 24,096.8 сая төгрөг, гэрээний биелэлт хангагдаагүй 20,773.5 сая төгрөгийн авлагатай байхад 2024 оны 2,3 дугаар сард нэмж 100 вагоны түрээсийн төлбөрт 5,767.7 сая төгрөг төлсөн, нийлүүлэгч талд давуу байдал олгосон байна.	1	5,767,700.0										1	5,767,700.0
Тайланд онд 25,146.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас 149.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, 2011-2021 онуудад үүссэн 443.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	592,297.4			1	592,297.4							

Сүмбэр дархан хүүд ХХК-аас авах авлагын үлдэгдэл 4738.61 ам.долларт Монголын олон улсын арбитрын 2023.12.21-ний өдрийн шийдвэрээр 2369.3 ам.доллар буюу 8.2 сая төгрөгийн алданги тооцохоор шийдвэрлэснийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	8,164.6					1	8,164.6				
Модерн Лайф Спарк ХХК-д нийлүүлсэн бетон зуурмагийн авлагын үлдэгдэл 108.9 сая төгрөгийг үндэслэлгүйгээр урьдчилж төлсөн тооцоо дансруу шилжүүлэн бүртгэсэн	1	108,943.2					1	108,943.2				
Тус үйлдвэрийн газрын өмнөх захирал Эрдэнэс Монгол ХХК-тай байгууллагын дүрэмд заасны дагуу "Онцгой нөхцөлт хөдөлмөрийн гэрээ"-г байгуулаагүй, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх" журмын дагуу гэрээг дүгнэж, урамшуулал олгох шийдвэргүйгээр захирал өөртөө 2023 оны жилийн эцсийн урамшуулалд 85.0 сая төгрөг, 2024 оны сар болон улирлын урамшуулалд 50.0 сая төгрөг, сар бүрийн урамшуулалд 6.0 мянган америк доллар буюу 157.7 сая төгрөг, нийт 292.7 сая төгрөгийн урамшуулал авсан байна.	1	292,728.6			1	292,728.6						
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан "Далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төслийн нэгжийн хөрөнгө оруулалтын төсвийг хэтрүүлэн 1.0 тэрбум төгрөгийн тавилга худалдан авах тендер зарлаж тайлант онд барилга нь баригдаж дуусаагүй байхад 150.0 сая төгрөгийн тавилга авч барилгын гадна тайлбайд хадгалсан байна.	1	150,000.0			1	150,000.0						

Ирээдүй цагийн зардал дансанд хэрхэн үүссэн нь тодорхойгүй, аль уулын ажлын зардал нь мэдэгдэхгүй 27.7 сая төгрөгийн зардлыг бүртгэсэн	1	27,657.1				1	27,657.1					
Эрхүүгийн төлөөлөгчийн газрын авлага 3.5 сая төгрөгийг найдваргүй авлага болгож данснаас хасахдаа, найдваргүй авлагын нөөц данснаас хасаагүй, мөн тайлант онд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй 531.7 сая төгрөгийн авлага байна.	1	535,287.7				1	535,287.7					
Нөхөн сэргээлтийн нөөц өр төлбөрийг Зүүн цагаан дэлийн далд уурхай дээр байгуулаагүй, урьд үүсгэсэн нөхөн сэргээлтийн нөөц санд жил бүр өөрчлөлт оруулаагүй байна	1					1						
ДҮН	10	7,556,513.3			3	1,035,026.0	6	753,787.3			1	5,767,700.0

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн 4,011.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/				
			Үүнээс				
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж		
				Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 161.0 сая төгрөгийн зарлагын 11 гүйлгээ, 110.6 сая төгрөгийн орлогын 12 гүйлгээ, мөн бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болох Нью стар энерги ХХК-тай байгуулсан эвлэрлийн гэрээ, Хэнтий аймгийн ЗДТГ-тай байгуулсан хамтран ажиллах гэрээ, Оросын холбооны улсад суралцах 9 оюутны сургалтын болон байр, хоолны төлбөр төлөх тухай захирлын тушаалыг шилэн дансанд хугацаа хоцроож байршуулсан	1	771,656.2	1	771,656.2			

Бор-Өндөр уулын баяжуулах үйлдвэр нь Бор-Өндөр сумын оршин суугчдын дулаан, цахилгаан, хэрэглээний усны төлбөрийг хариуцдаг бөгөөд тайлант оны эхний 11 сарын байдлаар тус нийгмийн шинж чанартай үйл ажиллагаанаас 3,240.1 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна. Айл өрхөөс авч байгаа цахилгааны төлбөрийг зах зээлийн жишигт нийцүүлэх шаардлагатай	1	3,240,061.0	1	3,240,061.0		
ДҮН	2	4,011,717.2	2	4,011,717.2		